



УВС АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 07 сарын 08 өдөр

дугаар 1/85

Улаангом

Тэмдэгтийн хураамжийн хэмжээг  
тогтоох тухай


МУ-ын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймагт мөрдөх тэмдэгтийн хураамжийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар баталж мөрдүүлсүгэй.

Хоёр: Батламж, гэрээний загварыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймгийн Засаг дарга / Э.Цасчихэр /-д даалгасугай.

Гурав: Тэмдэгтийн хураамжийн хэмжээг орон нутагт мөрдүүлэх ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс / Б.Норовсамбуу /-т, Татварын хэлтэс / Т.Шаравхүү /-т, Мэргэжлийн хяналтын газар / Д.Ганхуяг /-т тус тус даалгасугай.

ДАРГА



Д.БАТСАЙХАН



УВС АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2011 оны 07 сарын 08 өдөр

дугаар А/87

Улаангом

Тогтоол хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 21 дугаар тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 49 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт, 2009 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 78 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.БАТСАЙХАН

	үзлэг, шинжилгээ хийж гарал үүсэл, чанарыг тодорхойлон гэрчилгээ олгоход 2000 төгрөг;	
35.1.22	рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 320 000 төгрөг.	320000
35.2	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн Засаг дарга олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:	
35.2.1	спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 600 000 төгрөг, бусад суманд 300 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 200 000 төгрөг, бусад суманд 100 000 төгрөг;	600000 300000 200000 100000
35.2.2	спиртийн сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 150 000 төгрөг, бусад суманд 60 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 50 000 төгрөг, бусад суманд 30 000 төгрөг;	150000 60000 50000 30000
35.2.3	спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 500 000 төгрөг, бусад суманд 200 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 160 000 төгрөг, бусад суманд 80 000 төгрөг;	500000 200000 160000 80000
35.2.4	спиртийн сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгоход аймгийн төвийн суманд 160 000 төгрөг, бусад суманд 100 000 төгрөг, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгахад аймгийн төвийн суманд 80 000 төгрөг, бусад суманд 50 000 төгрөг.	160000 100000 80000 50000
35.3	Энэ хуулийн 35.2.1-д заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.2 дахь заалт, энэ хуулийн 35.2.3-т заасан тэмдэгтийн хураамж төлөгчид мөн хуулийн 35.2.4 дэх заалт тус тус хамаарахгүй.	
35.4	Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 40 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.	40000